

МЭДЭЭ · 2023 оны 6-р сарын 5

БНХАУ-ЫН АРДЫН ДЭЭД ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ







БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын төлөөлөгчид Монгол Улсын ерөнхий прокурорын газарт хийсэн айлчлалын хүрээнд хоёр улсын прокурорын байгууллага хоорондын ажил хэргийн уулзалтыг зохион байгуулав.

Тус арга хэмжээнд Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал, Сургалт судалгааны хүрээлэнгийн захирал Б.Бат-Орших, Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Ж.Болорпүрэв, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч прокурор А.Энхжаргал болон БНХАУ-ын Ардын дээд прокурорын газрын Прокурорын хорооны байнгын гишүүн Ван Чун, Ардын дээд прокурорын газрын Олон улсын хамтын ажиллагааны газрын дарга Руань Даньшөн, мэргэжилтэн Ли Шинкун, Жан Хонфен нар оролцлоо.

Хамтарсан уулзалтын үеэр хоёр улсын хооронд хүргүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлт, гэмт хэрэг үйлдэж оргон зайлсан хүнийг болон хууль бус хөрөнгө, орлогыг шилжүүлэн авах ажиллагааны хэрэгжилт, авлига албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэх чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагын талаар харилцан мэдээлэл солилцов.

Мөн прокурорын байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтарсан сургалт, судалгааны ажил зохион байгуулах, БНХАУ-ын эрх бүхий байгууллагад илгээсэн эрх зүйн туслалцааны хүсэлтүүдийг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх асуудлаар санал солилцож, хамтран ажиллахаар тохиролцлоо.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1908